



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага





ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР НЬ ЗОРИЛГО ТӨДИЙГҮЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ГОЛ ХӨДӨЛГҮҮР ЮМ

Хүмүүс илүү олноороо зохистой хөдөлмөр эрхэлнэ гэдэг нь эдийн засаг илүү хурдацтай, хүртээмжтэй өснө гэсэн үг. Өсөлт ийнхүү сайжирснаар зохистой ажлын байр бий болгоход зарцуулагдах нөөц нэмэгдэнэ. Энэхүү хялбар тэгшитгэлийг 2008 оны санхүүгийн хямралын өмнө ч, дараа нь ч олон улсын бодлого боловсруулах түвшинд бараг хайхраагүй юм. Тиймээс 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрөөр үүнийг өөрчилж, олон тэрбум хүний амьдралыг сайжруулах ховорхон боломж бидэнд тохиож байна.

Зохистой хөдөлмөр эрхэлснээр хүмүүс, гэр бүлүүд мөнгөтэй болж, худалдан авалт хийх замаар орон нутгийнхаа эдийн засагт хувь нэмэр оруулна. Тэдний худалдан авах чадвар нь эдийн засгийн өсөлт, тогтвортой үйлдвэрүүд, ялангуяа жижиг бизнесийн хөгжлийг дэмжиж, тэр хэрээр эргээд эдгээр нь илүү олон хүнийг ажилд авч, цалин хөлсийг нь нэмэгдүүлж, ажиллах нөхцөлийг нь сайжруулах боломжтой болно. Улмаар энэ нь татварын орлогыг нэмэгдүүлж, ажил олж чадахгүй байгаа, эсвэл ажил эрхлэх боломжгүй хүмүүсийг хамгаалах нийгмийн арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

ОУХБ-ын Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалын дөрвөн тулгуур нь ажлын байр, бизнесийг дэмжих, хөдөлмөрийн хүрээнд хүний эрхийг баталгаажуулах, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, нийгмийн түншлэлийг дэмжихэд чиглэдэг бөгөөд жендэрийн асуудал чиглэл бүрт хамаатай. Эдгээр нь тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй.

Бүх нийтээр зохистой хөдөлмөр эрхэлснээр тэгш бус байдлыг бууруулж, эрсдлийг даван туулах чадавхийг нэмэгдүүлнэ. Нийгмийн яриа хэлэлцээгээр боловсруулж гаргасан бодлого, шийдвэр нь хүмүүс, хамт олныг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, илүү тогтвортой эдийн засагт шилжих явцад тус болно. Зохистой хөдөлмөр

эрхэлсний үр дүнд олж авах нэр хүнд, итгэл найдвар, нийгмийн шударга ёсны мэдрэмж нь үүнээс ч дутуугүй ач холбогдолтой бөгөөд нийгмийн амгалан тайван байдлыг бүрдүүлж, хангахад нөлөөлнө.

Ийм ч учраас 2030 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрийг дэлхий даяараа хэлэлцэж байхад хүмүүс зохистой ажлын байрыг хамгийн чухал асуудлынхаа нэг хэмээн үзсэнд гайхах зүйлгүй билээ.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүүн хэлсэнчлэн 2030 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрийн зорилгууд нь “нийт хүн төрөлхтөн ядуурал, өлсгөлөн, тэгш бус байдлаас ангид зохистой түвшинд амьдрах чадавхийг бүрдүүлэх, түүнчлэн бүх эрэгтэй, эмэгтэйчүүд, охид, хөвгүүд өөрсдийн чадавхиа бүрэн хөгжүүлэх нөхцөлийг хангахад чиглэнэ. Эдгээр нь бид бүхэнд эх дэлхийнхээ хариуцлагатай иргэд байж, дэмжлэг хэрэгтэй нэгнээ халамжлах, амьтай бүхэнд хамаатай эх дэлхийнхээ экосистемийг хайрлан хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах арга хэмжээг тууштай авах үүргийг хүлээлгэж байгаа юм”.

Хөдөлмөрийн ертөнцөд тулгамдаж буй бэрхшээлийг бид дутуу илэрхийлж болохгүй. Дэлхийн ажилгүйдлийн түвшин хүлээн зөвшөөрөх аргагүй өндөр хэмжээнд хүрч, 200 орчим сая хүн ажилгүй байна. Мөн хэдэн зуун сая хүн ажилтай хирнээ ядуурлын түвшинд амьдарч байна. Түүнээс гадна ирэх 15 жилд технологи, хүрээлэн буй орчин, хүн ам зүйн өөрчлөлтөөс үүдэн бидний ажиллаж байгаа арга барилд ихээхэн өөрчлөлт гарахаар байна.

Гэхдээ засгийн газрууд, бизнес эрхлэгчид, үйлдвэрчний эвлэлүүд, түүнчлэн олон талт байгууллагууд, иргэний нийгмийнхэн, хүмүүс бид хамтаараа нягт түншлэн ажиллах аваас 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэтийн зорилгыг хэрэгжүүлж чадна. Хөгжлийн гадна хэнийг ч орхигдуулахгүй байхад хүн бүр, бид бүгдээрээ чухал үүрэгтэй.



Гай Райдер
ОУХБ-ын Ерөнхий Захирал



8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ





2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт бүх нийтийн зохистой хөдөлмөр эрхлэлт, ОУХБ-ын эрхэм зорилго, нийгмийн шударга ёс нь тогтвортой, хүртээмжтэй өсөлт, хөгжлийн бодлогын цөм нь болж тусгагдсан юм.

2008 оны санхүүгийн хямралаас хойш зарим орны эдийн засаг өсч, өсөлт нь тогтворжиж байна. Гэсэн хэдий ч ихэнх тохиолдолд эдгээр өсөлт нь ажлын байрыг нэмэгдүүлсэнгүй. Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгаа хэдий ч хүмүүст зохистой ажил эрхлэх боломж тэр бүр нэмэгдэхгүй байна. Энэ нь тогтвортой хөгжил хангагдахгүй байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр 2030 он гэхэд 600 саяас дээш ажлын байрыг шинээр бий болгох хэрэгцээ гарч байна. Энэ нь жил бүр 40 сая ажлын байр шаардагдана гэсэн үг.

Түүнчлэн ажилтай хэдий ч өдөрт 2 ам. доллар хүрэхгүй орлоготой учраас өөрсдийгөө болон гэр бүлээ ядуурлаас гаргаж чадахгүй байгаа 780 сая эмэгтэй, эрэгтэйчүүдийн амьжиргааны нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна.

Ажлын байр бий болгох асуудлыг эдийн засгийн бодлого, хөгжлийн төлөвлөлтийн цөм болгосноор зөвхөн зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлээд зогсохгүй, илүү тууштай, хүртээмжтэй, ядуурлыг бууруулсан өсөлтийг бий болгоно.

2000-аад оны эхэн үеэс чанартай ажлын байр бий болгоход түлхүү хөрөнгө оруулалт хийж байсан зарим хөгжиж буй болон эрчимтэй хөгжиж буй орнуудын эдийн засаг 2007 оноос хойш жилд бусдаасаа нэг орчим хувиар илүү өсч, орлогын тэгш бус байдал ч буурчээ.

Ажлын байр төвтэй эдийн засгийн өсөлт нь эдийн засагтаа ч хүн арддаа ч үр өгөөжтэй тасралтгүй дэвжих мөчлөг үүсгэдэг бөгөөд энэ нь тогтвортой хөгжлийг хөдөлгөгч хүч болдог.



8 **ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ**



ЗОРИЛГО



ТУУШТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БОЛОН БҮХ НИЙТИЙН БҮРЭН, БҮТЭЭМЖТЭЙ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

- 8.1** Үндэснийхээ нөхцөл байдалтай уялдуулан нэг хүнд ногдох эдийн засгийн өсөлтөө тууштай нэмэгдүүлэх, ялангуяа, буурай хөгжилтэй орнууд дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ өсөлтийг жилд 7 хувиас доошгүй байлгах.
- 8.2** Нэмүү өртөг өндөртэй, хөдөлмөр шингээлт ихтэй салбарыг хөгжүүлэхэд түлхүү чиглэсэн эдийн засгийг төрөлжүүлэх, технологийг шинэчлэх, инноваци нэвтрүүлэх замаар эдийн засгийн бүтээмжийг өндөр түвшинд хүргэх.
- 8.3** Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр, аж ахуй эрхлэх, бүтээлч сэтгэлгээ болон инновацийг хөхиүлсэн хөгжлийн бодлогыг дэмжих, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх болон бусад аргаар бичил, жижиг, дунд оврын үйлдвэрүүд албан хэвшилд шилжих, өсч хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх.
- 8.4** 2030 он гэхэд дэлхийн нөөцийн хэрэглээ, үйлдвэрлэлийн үр ашгийг дэвшилттэйгээр сайжруулах, “Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн асуудлаарх 10 жилийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгаль орчныг доройтуулж буй эдийн засгийн өсөлтийг хазаарлах талаар дорвитой хүчин зүтгэл гаргах, үүнд хөгжингүй орнууд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх.
- 8.5** 2030 он гэхэд бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийн бүрэн түвшинг хангаж, нийт эмэгтэй, эрэгтэйчүүд, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зохистой хөдөлмөр эрхлэх боломж бүрдүүлэх, ижил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох.
- 8.6** 2020 он гэхэд хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтаас гадуур байгаа залуучуудын эзлэх хувийг үлэмж бууруулах.
- 8.7** Албадан хөдөлмөрийг устгах, орчин үеийн боолчлол болон хүн худалдаалахыг таслан зогсоох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, түүний дотор цэргийн албанд хүүхдийг дайчлах, ашиглахыг хориглох, устгах талаар нэн яаралтай, үр дүнтэй арга хэмжээ авах, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг таслан зогсоох.
- 8.8** Бүх ажиллагчид, тэдний дотор цагаач ажиллагчид, ялангуяа цагаач эмэгтэйчүүд, баталгаагүй хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн эрхийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг баталгаажуулах.
- 8.9** 2030 он гэхэд ажлын байр бий болгох, нутгийн соёл, бүтээгдэхүүнийг сурталчлахад чиглэсэн тогтвортой аялал жуулчлалын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх.
- 8.10** Банк, даатгал, санхүүгийн үйлчилгээг бүх нийтээр хүртэх нөхцөл бололцоог нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор үндэсний санхүүгийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх.
- 8.а** Буурай хөгжилтэй орнуудад зориулсан Худалдааны асуудлаарх техникийн туслалцааны өргөжүүлсэн цогц хөтөлбөрийн хүрээнд хөгжиж буй орнуудын, ялангуяа буурай хөгжилтэй орнуудын худалдааг дэмжих тусламжийг нэмэгдүүлэх.
- 8.б** 2020 он гэхэд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх дэлхийн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, ОУХБ-ын Дэлхийн ажлын байрны пактыг хэрэгжүүлэх.

8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ



© M. Crozet / OIT

Жижиг бизнесийг дэмжин зохистой ажлын байр бий болгох нь

Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр, аж ахуй эрхлэлт, бүтээлч сэтгэлгээ болон инновацийг хөхиулсэн хөгжлийн бодлогыг дэмжих, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх болон бусад аргаар бичил, жижиг, дунд оврын үйлдвэрүүд албан хэвшилд шилжих, өсч хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх

Дэлхийн нийт ажлын байрны гуравны хоёроос доошгүйг бичил, жижиг, дунд оврын үйлдвэрүүд (БЖДҮ) бий болгож байдаг. Зээл авах боломж нь хязгаарлагдсан учир санхүүгийн хямрал тэдэнд хамгийн хүндээр туссан байдаг. Жижиг үйлдвэрийн газрууд хөдөлмөрийн нөхцөл нь зохицуулалтад ороогүй албан бус хэвшилд хамаарах нь түгээмэл байдаг.

Юу хийх шаардлагатай вэ?

- Хөдөлмөрийн зах зээл хувьсан өөрчлөгдөж, бизнес эрхлэлт бэхжихийн хэрээр ирэх жилүүдэд жижиг бизнест дэмжлэг хэрэгтэй байна. Шинээр бий болох компаниудын хэмжээ, бүтэц, салбарынх нь шинж байдлыг харгалзсан бодлого гаргаж дэмжих шаардлагатай.
- Санхүүгийн үйлчилгээ ч хялбар, хүртээмжтэй байх шаардлагатай, үйлдвэр аж ахуйн газрууд цэцэглэн хөгжих зөв нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй. Хөдөлмөрийн нөхцөлийг ч сайжруулж, БЖДҮ-дийг албан хэвшилд шилжихэд нь туслах шаардлагатай.

8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ



ЗОРИЛГО

© P. Delacoste / QIT

Бүх хүн зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх

2030 он гэхэд бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийн бүрэн түвшинг хангаж, нийт эмэгтэй, эрэгтэйчүүд, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зохистой хөдөлмөр эрхлэх боломж бүрдүүлэх, ижил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох

Дэлхийн хэмжээнд 200 сая гаруй хүн ажилгүй байна. Олон оронд бүрэн ажил эрхлэлтийг хангах зорилт хэрэгжих боломжгүй хэвээр байна. Бид ажилгүйчүүдийн тоог бууруулъя гэвэл бүрэн ажил эрхлэлтийг үндэсний болоод олон улсын түвшний макро эдийн засгийн бодлогын гол зорилт болгох хэрэгтэй.

Дэлхийн өнцөг булан бүрт эмэгтэйчүүд үнэлгээ муутай, бага цалин хөлстэй ажил эрхэлж, боловсрол эзэмших, сургалтад хамрагдах, ажилд орох боломжоор хязгаарлагдмал байх нь түгээмэл байна. Тэдний хэлцэл хийх, шийдвэр гаргах хүч сул, цалин хөлсгүй асран халамжлах ажлын ихэнхийг үүрдэг хэвээр байна. Дэлхийн нийт эрэгтэйчүүдийн 80 орчим хувь нь ажил эрхэлж байгаатай харьцуулахад эмэгтэйчүүдийн дөнгөж тал хувь нь л хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд тэд эрэгтэйчүүдийнхээс 23 хувиар доогуур цалин хөлс авч байна. Энэ нь эхчүүдэд хүндээр тусч байна.

Юу хийх шаардлагатай вэ?

- Ажлын байр бий болгох, эрэлт, хөрөнгө оруулалтыг дэмжсэн макро эдийн засгийн бодлого, бүтээмж нэмэгдүүлэхэд чиглэсэн татвар, дэд бүтэц, салбарын тусгайлсан бодлогуудыг эн тэргүүнд тавих.
- Зээлийн урсгалыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, жижиг бизнесийг дэмжих, улмаар тэднийг албан бус хэвшлээс албан хэвшилд шилжихийг хөхиүлэн дэмжсэн бодлогуудыг батлан гаргах.
- Тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн хүн төвтэй бодлогыг гаргаж хэрэгжүүлэх. Үүнд нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд, цалин хөлсний бодлого, хөдөлмөрийн хяналтыг бэхжүүлэх, хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын хэлэлцээ хийх эрхийг хангах зэрэг орно.
- Эмэгтэйчүүд ажил эрхлэхийг дэмжиж, эхчүүдийн шударга хамгаалал, ажил-гэр бүлийн үүрэг хариуцлагыг тэнцвэржүүлсэн бодлогын үр шимийг хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ



ЗОРИЛГО

© François Nascimbene / AFP

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

2020 он гэхэд хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтаас гадуур байгаа залуучуудын эзлэх хувийг үлэмж бууруулах

2014 оны байдлаар дэлхийд 73 сая гаруй (15-24 насны) залуучууд ажил хайж байжээ. Нийт залуучуудын тавны нэгээс илүү хувь нь ажил эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байжээ. Үүнээс гадна 2013 онд хөгжиж байгаа орнуудад ажил эрхэлж байгаа нийт залуучуудын гуравны нэгээс илүү нь өдөрт 2 ам.доллар хүрэхгүй орлоготой ядуурлын түвшинд амьдарч байв.

Сургууль завсардагчид дийлэнхдээ ажилгүй, аль эсвэл эрх нь зөрчигдсөн, баталгаагүй нөхцөлд ажил эрхэлж, ядууралд өртөж байна.

Залуу насандаа ажилгүйдэлд өртөж, аль эсвэл бүрэн бус ажил эрхлэх нь тэдний цаашдын ажил, амьдралд арилшгүй муу нөлөө үзүүлнэ.

Боловсрол, сургалтаар дамжуулан бүтээмжийг нэмэгдүүлэх, ажил эрхлэлтийг тоо болон чанарын хувьд сайжруулах, улмаар эдийн засгийн өсөлтөд хүрэх гэсэн үр өгөөжтэй тасралтгүй дэвжих мөчлөгийг бий болгох нь нийгмийн болоод эдийн засгийн асар их ашиг тустай.

Юу хийх шаардлагатай вэ?

- Залуучуудад ажил хайх, шинээр үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх гэх мэт зорилтот интервенцүүдийг хэрэгжүүлэх замаар ажлын байр бий болгох болон өсөлтийг дэмжсэн цогц стратегийг тэнцвэржүүлэх залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн стратеги гаргах.
- Техник мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрт ажлын туршлага хуримтлуулах агуулгыг оруулах, сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэх замаар ур чадварын үл нийцлийн асуудлыг шийдвэрлэх.
- Эрсдэлтэй хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын орлогын баталгааг сайжруулахын тулд нийгмийн хамгааллын шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулах.

8

ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ



Албадан хөдөлмөр ба хүүхдийн хөдөлмөр

Албадан хөдөлмөрийг устгах, орчин үеийн боолчлол болон хүн худалдаалахыг таслан зогсоох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, түүний дотор цэргийн албанд хүүхдийг дайчлах, ашиглахыг хориглох, устгах талаар нэн яаралтай, үр дүнтэй арга хэмжээ авах, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг таслан зогсоох

Дэлхийн нийт хүүхдийн 10-аас илүү хувь буюу 168 сая хүүхэд хөдөлмөр эрхэлж байна. Энэ тоо 2000 оноос хойш буурч байгаа хэдий ч хүлээн зөвшөөрөх аргагүй өндөр хэвээр байна.

Дэлхийд 21 сая хүн албадан хөдөлмөр эрхэлж байгаагийн 11 сая гаруй нь эмэгтэйчүүд, охид байна. Эдгээр хохирогчдын дийлэнх нь жилд дунджаар 150 тэрбум гаруй ам.долларын хууль бус ашиг олж байгаа хувь хүн, аж ахуйн газруудын золиос болж байна.

Юу хийх шаардлагатай вэ?

- Хүүхдийн болоод албадан хөдөлмөртэй тэмцэх талаарх олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг улс орнууд үндэснийхээ түвшинд ягштал хэрэгжүүлэх шаардлагатай.
- Хүүхдийн хөдөлмөрийг устгахад хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, бүх хүүхдэд боловсрол эзэмшүүлэх, гэр бүлийнхнийг нь нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн зах зээлийн бодлогод хамруулах зэргийг багтаасан олон талт арга барил шаардлагатай.
- Орчин цагийн боолчлолын хэлбэрүүдийг устгахтай холбоотой заалтууд орсон ОУХБ-ын албадан хөдөлмөрийн тухай 2014 оны Протоколд улс орнууд нэгдэн орох.

8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ



© M. Crozet / OIT

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Бүх ажиллагчид, тэдний дотор цагаач ажиллагчид, ялангуяа цагаач эмэгтэйчүүд, баталгаагүй хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн эрхийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг баталгаажуулах

Өдөрт дунджаар 6,400 орчим хүн буюу жилд дунджаар 2,3 сая хүн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас амь насаа алдаж байна. Түүнчлэн өдөрт 860,000 хүн ажлын байрандаа бэртэж гэмтэж байна. Энэ бүхний улмаас алдагдсан ажлын цаг, үйлдвэрлэлийн зогсолт, үйлдвэрлэлийн ослын бэртэл гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчний эмчилгээ, нөхөн сэргээлт, нөхөн олговорт зарцуулсан зардал зэргийг тооцвол жилд дунджаар 2,8 их наяд ам. доллар буюу дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувьтай тэнцэхүйц хэмжээний зардал бизнест учирч байна.

Юу хийх шаардлагатай вэ?

- Хүний эрүүл, аюулгүй орчин нөхцөлд ажиллах эрхийг хангах, ажил олгогчид, ажиллагчид өөрсдийн эрх, үүрэг хариуцлагаа ухамсарлаж урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх талаар нэн даруй арга хэмжээ авах.
- ОУХБ-аас тогтоосон үндсэн эрх, хэм хэмжээг улс орнууд ягштал хэрэгжүүлэх нь нэн чухал. Цагаачлан ажиллагчид болон эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг нь сайжруулах талаар онцгой анхаарал тавих шаардлагатай.

8 **ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ**



ЗОРИЛГО

© Sofie Tesson / Taimani Films / Barco Mundial

Бүрэн хэрэгжилтийн төлөө

2020 он гэхэд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх дэлхийн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, ОУХБ-ын Дэлхийн ажлын байрны пактыг хэрэгжүүлэх

Дэлхийн санхүүгийн хямралын дараахан буюу 2009 онд засгийн газрууд, ажил олгогчид, ажилчид хамтаараа ОУХБ-ын Дэлхийн ажлын байрны пактыг баталсан билээ. Энэхүү пактаар улс орнуудын амжилттай хэрэгжүүлсэн бодит туршлагад үндэслэн боловсруулсан зохистой ажлын байр бий болгох үйл явцыг түргэтгэх, нийгмийн хамгааллын тогтолцоогоо хөгжүүлэх, тогтвортой байлгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг зөвлөмж болгосон байна.

Түүнчлэн нийтийн дэд бүтцэд хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэлтийн тусгай хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх зэрэг хувилбаруудыг авч үзэхийг засгийн газруудад уриалсан юм.

Мөн ОУХБ-ын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх 2012 оны тогтоолд залуучуудын хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр туршигдаж, шалгарсан багц арга хэмжээнүүдийг санал болгосон байна.

Их 20-ийн орнууд ажлын байр бий болгох болон нийгмийн хамгаалалд нэн тэргүүнд анхаарал хандуулахаа илэрхийлж, удаа дараагийн Дээд хэмжээний уулзалтынхаа албан ёсны мэдэгдэлд тусгаснаас үзэхэд эдгээрийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл байна. Гэхдээ 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрт дэвшүүлсэн өөрчлөлтийг хийхийн тулд олон улсын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг бэхжүүлэх дэлхий нийтийн түншлэлийг өргөжүүлэх шаардлага гарч байна.

Олон жилийн түүхтэй гурван талт байгууллагын хувьд ОУХБ-ын туршлага үүнд маш чухал хувь нэмэр оруулна. Бараг нэгэн зууны туршид манай удирдлагын бүтцэд засгийн газар, бизнес эрхлэгчид болон үйлдвэрчний эвлэлийнхний төлөөлөл оролцож ирсэн.

ОУХБ нь энэхүү гурван талт бүтэцдээ тулгуурлан хөрөнгө нөөцөө үр ашигтай зарцуулж, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг залах шинэ түншлэлд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

2030 ОН ХҮРТЭЛХ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭС СУУРЬ НЬ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЮМ. ДАРААГИЙН ХЭСЭГТ ХӨГЖЛИЙН ГАДНА ХЭН Ч ОРХИГДОХГҮЙ БАЙХЫГ БАТАЛГААЖУУЛАХЫН ТҮЛД ОУХБ-ААС ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЖ БҮЙ ЗОРИЛТУУДЫН ТАЛААР ӨГҮҮЛНЭ.

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хуудаст зочилно уу: www.ilo.org/sdg2030

1 ядуурлыг устгах



ЗОРИЛГО



Ядуу зүдүү амьдарч байгаа хүмүүсийн хамгийн чухал өмч бол тэдний өөрсдийнх нь хөдөлмөрлөх чадавх, бүтээмжтэй ажиллах чадвар юм. Тиймээс бүх нийтийг зохистой хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж, нийгмийн хамгаалалд хамруулах нь хувь хүн, хамт олон, улс орон ядуурлаас гарах гол зам болно.

- 1.1 Өдөрт 1,25 ам.доллараас бага орлоготой амьдарч байгаа хүмүүсийг нэн ядууд тооцдог бөгөөд 2030 он гэхэд дэлхий нийтээрээ нэн ядуурлыг үндсээр нь устгах.
 - 1.2 Үндэснийхээ үзүүлэлтээр ядуурлын түвшинд амьдарч буй бүх эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхдийн тоог тэн хагасаас доошгүй хувиар бууруулах.
 - 1.3 Үндэснийхээ нөхцөл байдалд тохирсон нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.
- 1.4 Эрэгтэй, эмэгтэй бүх хүн адилхан эдийн засгийн нөөц ашиглах, бичил санхүүгийн үйлчилгээнд хамрагдах тэгш эрхийг баталгаажуулах.
 - 1.5 2030 он гэхэд ядуу болон эмзэг, эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүмүүсийг аливаа эрсдэлийг даван туулах чадвартай болгох, тэднийг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй онцгой нөхцөл, бусад эдийн засаг, нийгмийн хямрал, байгалийн гамшгийн аюулд нэрвэгдэхээс сэргийлэх, хамгаалах.
 - 1.b Ядуурлыг устгахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлж дэмжихийн тулд үндэсний болон бүс нутгийн, олон улсын түвшинд ядуурал, жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн стратегид тулгуурласан ухаалаг бодлогын хүрээг тодорхойлох.





2 ӨЛСГӨЛӨНГ ЗОГСООХ

Хүнсний үйлдвэрлэлд ажиллах хүч түлхүү шаарддаг учир бусад салбартай харьцуулахад хөдөө аж ахуйн салбарт илүү олон хүн ажилладаг. Нэн ядуусын дийлэнх нь хөдөө орон нутагт хөдөө аж ахуйгаас олсон орлогоор амьдралаа залгуулж байна. Тиймээс энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд тогтвортой хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөрийг бий болгох нь нэн чухал үүрэгтэй.

2.3 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, хүнсний жижиг үйлдвэрлэгчдийн орлогыг хоёр дахин нэмэгдүүлэх.

2.4 Үйлдвэрлэл, бүтээмжийг нэмэгдүүлэх хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой аргуудыг нэвтрүүлэх.



© foodwastealliance.org

ЗОРИЛГО



3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ



ЗОРИЛГО

© Banco Mundial

Ажилчид нь эрүүл, ажлын нөхцөл нь зохистой, аюулгүй байх аваас ажиллах хүчний үйлдвэрлэн бүтээх чадавхийг нэмэгдүүлнэ. Харин эрүүл мэндийн шаардлагатай тусламж, үйлчилгээний дутагдал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хүмүүс ажил эрхлэх боломжгүй болж улмаар ядууралд өртөх эрсдэлтэй. Үүний зэрэгцээ дэлхий даяар урьд өмнөхөөс илүү олон хүн эрүүл мэндийн салбарт ажиллах болж байгаа бөгөөд өөр хангагдах бүх нийтэд эрүүл мэндийн хэрэгцээт тусламж, үйлчилгээг хүргэхийн тулд тэд ч мөн хөдөлмөрийн зохистой нөхцөлөөр хангагдах шаардлагатай.

3.3 2030 он гэхэд ДОХ-ын тархалтыг таслан зогсоох.

3.8 Бүх нийтээр эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагддаг болох.

3.9 2030 он гэхэд химийн хорт бодис, агаар, ус, хөрсний бохирдол, халдвараас үүдэлтэй эндэгдэл, өвчлөлийн тоог үлэмж бууруулах.



4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

Боловсрол эзэмшсэнээр, ялангуяа залуучууд зохистой ажлын байр олох боломжтой болох бөгөөд хувьсан өөрчлөгдөж байдаг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцэх ур чадварыг олж авч байх насан туршийн сургалт тэдэнд мөн хэрэгтэй.

4.4 2030 он гэхэд ажил эрхлэх, зохистой ажлын байранд ажиллах, бизнес эрхлэхэд шаардагдах ур чадвар, түүний дотор техникийн болон мэргэжлийн ур чадвартай залуучууд, насанд хүрэгсдийн тоог үлэмж нэмэгдүүлэх.

4.5 Боловсрол дахь жендэрийн тэгш бус байдлыг арилгах, бүх шатны боловсролд бүх нийтээр тэгш хамрагдах нөхцөлийг хангах.

4.b 2020 он гэхэд хөгжиж байгаа орнуудын суралцагсдад олгодог дээд боловсрол эзэмших болон техник мэргэжлийн сургалтад хамрагдах сургалтын тэтгэлгийн тоог дэлхийн хэмжээнд дорвитой нэмэгдүүлэх.

4.c 2030 он гэхэд мэргэжлийн багш нарын хангамжийг үлэмж нэмэгдүүлэх.



ЗОРИЛГО

4

5 ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ



ЗОРИЛГО

Эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд чадавхжуулах нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах суурь нөхцөл болно. Эмэгтэйчүүд эдийн засгийн эрх мэдэлтэй, нэр төртэй амьдрах гол эх сурвалж нь ажилтай байх юм. Иймээс хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн ялгаатай байдлыг арилгах, нийт эмэгтэйчүүдийг зохистой хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, ижил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгодог байх нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах гол түлхүүр нь юм.

5.1 Эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах.

5.2 Нийгмийн болоод хувийн амьдралд эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг, түүний дотор охид, эмэгтэйчүүдийг худалдаалахыг таслан зогсоох.

5.4 Төрийн үйлчилгээ, дэд бүтэц, нийгмийн хамгааллын бодлого болон өрх, гэр бүлд үүрэг хариуцлагаа хуваалцдаг болохыг дэмжих зэрэг үндэснийхээ нөхцөлд тохирсон арга замаар цалин хөлсгүй гэрийн болон асран халамжлах ажлыг хүлээн зөвшөөрөх, үнэлэх.

5.5 Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийг бүрэн, үр нөлөөтэй оролцуулах, манлайлах тэгш боломжоор хангах.

5.a Эмэгтэйчүүдэд эдийн засгийн нөөцийг ашиглах тэгш эрх олгохуйц эрс шинэчлэлтийг хийх.

5.c Жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих, бүх түвшинд эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулахад чиглэсэн ээлтэй бодлого, хэрэгжих боломжтой хууль тогтоомжийг гаргаж мөрдөх.



6 БАТАЛГААТ УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ

Усны олдоц, чанар, хэмжээ ажилчдын амьдралд нөлөөтэй. Ундны ус, ариун цэврийн байгууламжид хөрөнгө оруулснаар цалин хөлстэй ажил, зохистой ажлын байрыг бий болгож тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна.


6.3 2030 он гэхэд дэлхий дахинд усны бохирдлыг бууруулах, усанд хог хаягдал хаяхыг таслан зогсоох, химийн хорт бодис, материалын хаягдал, ялгаруулалтыг багасгах, боловсруулаагүй бохир усны хаягдлын хэмжээг хоёр дахин бууруулах, хаягдал усыг дахин боловсруулж, аюулгүй ашиглах зэргээр усны чанарыг сайжруулах.



© Banco Mundial

ЗОРИЛГО

7 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ



Ногоон эдийн засагт шилжихэд ОУХБ-аас гаргасан зохистой хөдөлмөрийн зарчимд суурилсан “Бүх нийтээр байгаль орчинд ээлтэй тогтвортой эдийн засаг, нийгэмд зохистой шилжих удирдамж”-ийг мөрдөх нь зүйтэй.

- 7.1 2030 он гэхэд бүх нийтийг боломжийн үнэ өртөгтэй, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хангах.
- 7.2 2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жинг үлэмж нэмэгдүүлэх.
- 7.b 2030 он гэхэд хөгжиж байгаа орнууд, ялангуяа буурай хөгжилтэй орнууд, далайд гарцгүй болон жижиг арлын хөгжиж буй орнуудад бүх нийтийг орчин үеийн, тогтвортой эрчим хүчний үйлчилгээгээр хангахад шаардагдах дэд бүтцийг холбогдох хөтөлбөрүүдийнхээ хүрээнд, өргөжүүлэх, технологийг шинэчлэх.






9 ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Хөдөлмөрийн ертөнцөд аж үйлдвэрийн хөгжил чухал ач холбогдолтой бөгөөд энэхүү хөгжлийг хүртээмжтэй, шинэлэг, нийгмийн хувьд хариуцлагатай болгоход зохистой хөдөлмөр зайлшгүй юм. Дэд бүтцийг хөгжүүлэх хөдөлмөр зарцуулалт ихтэй хөтөлбөрүүд нь ядуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх ихээхэн боломжийг бий болгоно.

- 9.1 Эдийн засгийн хөгжил, хүний сайн сайхан аж байдлыг дэмжихийн тулд чанартай, найдвартай, тогтвортой, бат бэх дэд бүтцийг хөгжүүлэх.
- 9.2 Хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг дэмжиж, аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын хувийг үлэмж нэмэгдүүлэх.
- 9.3 Үйлдвэрлэлийн болон бусад чиглэлийн жижиг аж ахуйг санхүүгийн үйлчилгээ, өртгийн сүлжээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх.



© M. Crozet / OIT

ЗОРИЛГО



10 ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ



Шударга орлого, ажлын байрны аюулгүй байдал, хувь хүн болон гэр бүлийн нийгмийн хамгааллыг онцолдгоороо зохистой хөдөлмөр нь орлого, хөрөнгө чинээ, эдийн засгийн нөлөөллийн тэгш бус байдлыг бууруулахад шууд нөлөөлөх арга хэрэгсэл юм.

- 10.1** Хүн амын хамгийн орлого багатай 40 хувийн орлогыг аажим нэмэгдүүлж, тогтворжуулах.
- 10.2** Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болоод бусад байдлыг нь үл харгалзан хүн бүрийн нийгэм, эдийн засаг, улс төрийн оролцоог хөхиүлэн дэмжиж, чадавхжуулах.
- 10.3** Ялгаварлан гадуурхалтыг бий болгож буй аливаа хууль, бодлого, практикийг халж, зохих хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг дэмжих болон бусад замаар тэгш боломжийг баталгаажуулах, тэгш бус байдлын үр дагаварыг бууруулах.
- 10.4** Төсөв, цалин хөлс, нийгмийн хамгааллын болон бусад асуудлаар зохих бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах.
- 10.5** Дэлхийн санхүүгийн зах зээл, институцийн зохицуулалт, хяналтыг сайжруулах, эдгээр зохицуулалтын хэрэгжилтийг хангах.
- 10.6** Дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудыг илүү үр ашигтай, итгэл даасан, хариуцлагатай, хууль ёсны инститүц болгох үүднээс тэдний шийдвэр гаргах үйл явцад хөгжиж байгаа орнуудын төлөөлөл, дуу хоолойг нэмэгдүүлэх.
- 10.7** Эмх журамтай, аюулгүй, хууль ёсны, хариуцлагатай шилжих хөдөлгөөнийг дэмжих.
- 10.c** 2030 он гэхэд шилжих хөдөлгөөнд оролцогчдын мөнгөн гуйвуулгын хураамжийг бууруулж 3-аас доош хувьд хүргэх, 5-аас дээш хувийн хураамжтай гуйвуулгын сувгуудыг хаах.




11 ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ

Зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох нь тогтвортой хот суурин газрыг хөгжүүлэх суурь нөхцөл юм. Хот газрын хөдөлмөрийн зах зээлийн хөгжиж байгаа арга зам нь эргээд тэдний ажлын байр бий болгох замаар ядуурлыг бууруулахуйц зохистой хөдөлмөр эрхлэлтийг бий болгож чадах эсэхийг шийдвэрлэнэ. Хотжих үйл явцад нийцсэн Зохистой хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр нь хотыг илүү бүтээмжтэй, хүртээмжтэй, тогтвортой болгоно.

- 11.1 2030 он гэхэд бүх нийтийг зохистой, аюулгүй, боломжийн үнэ өртөгтэй орон сууцаар хангаж, суурь үйлчилгээнд бүрэн хамруулах.
- 11.2 Бүх нийтийг аюулгүй, боломжийн үнэ өртөгтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн үйлчилгээгээр бүрэн хангах.
- 11.с Буурай хөгжилтэй орнуудад орон нутагтаа олдоцтой материалыг ашиглан тогтвортой, бат бэх барилга байгууламж барихад нь дэмжлэг үзүүлэх.



ЗОРИЛГО



12 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ



ЗОРИЛГО



Хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтцэд гарч буй өөрчлөлтийн улмаас хөдөлмөр эрхлэлтэд гарах өөрчлөлтийг зохистой хэрэгжүүлэх нь энэхүү зорилгод хүрэхэд тун чухал. Бүх нийтээр зохистой хөдөлмөр, ялангуяа ногоон ажил эрхэлснээр хөгжлийг байгаль орчны хувьд ээлтэй болгоход хувь нэмрээ оруулна.

12.1 Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн асуудлаарх 10 жилийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

12.4 2020 он гэхэд олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу химийн бодис, бүх төрлийн хог хаягдлын байгаль орчинд халгүй менежментийг бүрдүүлэх, тэдгээрийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн доод түвшинд хүргэх зорилгоор агаар, ус, хөрсөнд хаяхыг эрс бууруулах.

12.6 Компаниуд үйлдвэрлэлийн тогтвортой аргуудыг нэвтрүүлж, энэ талаарх мэдээллийг үйл ажиллагааны тайланд тусгадаг болохыг дэмжих.

12.a Хэрэглээ, үйлдвэрлэлийн илүү тогтвортой бүтцэд шилжих зорилгоор шинжлэх ухаан, технологийн чадавхиа бэхжүүлэхэд нь хөгжиж байгаа орнуудад дэмжлэг үзүүлэх.

12.b Шинээр ажлын байр бий болгодог тогтвортой аялал жуулчлалд тогтвортой хөгжлийн үзүүлж буй нөлөөллийг хянах арга хэрэгслийг боловсруулж, хэрэгжүүлэх.



13 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ

Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулахад хөдөлмөрийн хүрээнийхний идэвхтэй оролцоо шаардагдах бөгөөд зохистой хөдөлмөрийн үзэл баримтлал, түүнчлэн ОУХБ-аас гаргасан “Бүх нийтээр байгаль орчинд ээлтэй тогтвортой эдийн засаг, нийгэмд зохистой шилжих удирдамж” –ийн хэрэгжилт ихээхэн хувь нэмэр оруулна.

13.1 Бүх улс орны уур амьсгалын өөрчлөлтийн уршиг нөлөө, байгалийн гамшгийн эрсдэлийг даван туулах болон түүнд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх.



ЗОРИДГО

13

14 ДАЛАЙ ТЭНГИСИЙН НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ



ЗОРИЛГО



© Banco Mundial

Бүх нийтийг зохистой хөдөлмөр эрхлэх нөхцөлөөр хангах, түүний дотор дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж буй далайчид, загасчдыг хөдөлмөрийн зохистой нөхцөлөөр хангаж, шударга цалин хөлс олгох нь далай тэнгисийн нөөцийг хамгаалах, хэт загасчлалыг багасгах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

14.4 Загас агнуурыг үр дүнтэй зохицуулах, хэт загасчлал, хууль бус, бүртгэлгүй, зохицуулалтгүй загас агнуурын үйл ажиллагааг таслан зогсоох.

14.6 2020 он гэхэд загасны нөөцөд хохирол учруулах, нөөцийг хэтрүүлэн ашиглахад хүргэж буй загас агнуурын татаасын зарим хэлбэрийг хязгаарлах, хууль бус, бүртгэлгүй, зохицуулалтгүй агнуур бий болоход хүргэж мэдэх татаас дэмжлэгийг таслан зогсоох.

14.7 2030 он гэхэд загасны аж ахуй, үржүүлэг, аялал жуулчлалын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замаар буурай хөгжилтэй болон жижиг арлын хөгжиж байгаа орнуудын далай тэнгисийн нөөцийн тогтвортой ашиглалтын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх.



15 ХУУРАЙ ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙГ ХАМГААЛАХ

Ядуурлыг бууруулахад чиглэсэн үндэсний болон орон нутгийн хөгжлийн стратегид газрын экосистемийг хамгаалах асуудлыг тусгахын тулд газрын үр шимээр амьдардаг бүх ажилчдыг зохистой хөдөлмөр эрхлэх боломжоор хангахад онцгойлон анхаарах шаардлагатай.

15.b Ойн тогтвортой менежментийн санхүүжилтийг бүх төрлийн эх үүсвэрээс, бүх түвшинд үлэмж хэмжээгээр дайчлах.



© Andrew Coelho

ЗОРИЛГО

15

16 ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ



ЗОРИЛГО

© Banco Mundial

Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд үндэслэж, нийгмийн яриа хэлэлцээгээр тодорхойлсон бүх нийтийн зохистой хөдөлмөрийг дэмждэг үр нөлөөтэй, нээлттэй институцууд нь шударга, энх амгалан нийгмийг цогцлоох, оролцоог хангасан шийдвэр гаргах суурь нөхцөл болно.

- 16.2** Хүүхдийн эрхийг зөрчих, мөлжих, худалдаалах, тарчлаах болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох.
- 16.3** Үндэсний болон олон улсын түвшинд эрх зүйт ёсыг дээдлэх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нөхцөлийг баталгаажуулах.
- 16.6** Үр нөлөөтэй, хариуцлагатай, нээлттэй, чадварлаг институцийг бүх шатанд бий болгох.
- 16.7** Хариуцлагатай, нээлттэй, оролцоо, төлөөлөл хангасан шийдвэр гаргах тогтолцоог бүх шатанд нэвтрүүлэх.
- 16.8** Дэлхийн хэмжээний удирдлагын институцүүдэд хөгжиж байгаа орнуудын оролцоог өргөжүүлж, бэхжүүлэх.
- 16.10** Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу олон нийтийн мэдээлэл авах боломжоор хангах, хүний үндсэн эрх чөлөөг хамгаалах.
- 16.a** Олон улсын хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр хүчирхийллээс сэргийлэх, терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний институцийн чадавхийг бүх түвшинд бэхжүүлэх.
- 16.b** Тогтвортой хөгжлийг хангахын төлөө үл ялгаварлан гадуурхсан хууль, бодлогыг дэмжих, хэрэгжүүлэх.



17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ

Хөдөлмөрийн хүрээн дэх түншлэл нь Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн түншлэлийн нэгэн гол хэсэг юм. Ажил олгогчид, ажилчдын байгууллагууд, засгийн газрууд, олон улсын түншүүдтэй хамтран ажиллах чадавхийг бэхжүүлэх нь 2030 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрийн зохистой хөдөлмөрийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэх чухал нөхцөл болно.

- 17.9 Хөгжиж байгаа орнуудад үр өгөөжтэй, чадавхи бүрдүүлэх зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн олон улсын дэмжлэгийг өргөжүүлэх.
- 17.13 Бодлогын зохицуулалт, уялдаа холбоог хангах замаар даян дэлхийн макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх.
- 17.14 Тогтвортой хөгжлийн асуудлаарх бодлогын уялдаа холбоог бэхжүүлэх.
- 17.17 Төрийн болон төр-хувийн хэвшлийн, иргэний нийгэм хоорондын түншлэлийг хөхиүлэн дэмжиж хөгжүүлэх.
- 17.18 Өндөр чанартай, шуурхай, найдвартай мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хөгжиж байгаа орнуудын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг өргөжүүлэх.



© Banco Mundial

ЗОРИЛГО





ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ЗӨРИЛТУУД

International Labour Organization (ILO)

Department of Communication and Public Information

4, route des Morillons
CH-1211 Geneva 22
Switzerland

Tel: +41 22 799 79 12

Fax: +41 22 799 85 77

Email: communication@ilo.org

Visit: www.ilo.org

Follow us:

www.facebook.com/ilo.org

www.twitter.com/ilo

www.youtube.com/ILOTV